



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1110

Улаанбаатар хот


Аян зохион байгуулах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулах Сар шинийн баярыг угтсан "Хоггүй шинэлцгээ" аяны удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт аяныг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, хуваарь, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавьж, харьяа төр захиргааны болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт, төвийн бүсийн аж ахуйн нэгж, байгууллагууд болон орон сууцны хорооллын хог хаягдлыг оройн 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд тээвэрлэх, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг аяны хугацаанд 2-оос доошгүй удаагийн давтамжтай тээвэрлэх нэмэлт хуваарь гарган мөрдөж ажиллахыг Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж бүх нийтийн их цэвэрлэгээний тайлан, дүн мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын ерөнхий менежерийн
2020 оны 01-р сарын 24-ны
өдрийн А/16 дугаар тушаалын хавсралт



“ХОГГҮЙ ШИНЭЛЦГЭЭ” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго.

1.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил хашаа, талбайд хуримтлагдсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх, гэрлийн шонг угаах, шон дээр наасан зарлал, наалтыг хуулах нийтийн эзэмшлийн эд хогшил, хөшөө дурсгал, хогийн сав, сандал, хайс хашлагыг угааж цэвэрлэх, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хаягийн байгууламжуудыг угаах, өнгийг сэргээх зэрэг чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудыг цэвэрлэгээний үйл ажиллагаанд идэвхжүүлэн оролцуулах, хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын хог тээвэрлэлтийг сайжруулах сар шинээр хоггүй шинэлэхэд энэхүү удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Аян зохион байгуулах хугацаа.

2.1. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2020 оны 01-р сарын 24-ний өдрөөс 02-р сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулж, хамтран оролцох байгууллага:

3.1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн харьяа газар, агентлагууд, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, их дээд болон ерөнхий боловсролын сургуулиудын оюутан сурагчид, хороод, Сууц өмчлөгчдийн холбоод, иргэд.

Дөрөв. Зохион байгуулах, хамтран оролцогчдын үйл ажиллагаа:

№	Байгууллага	Хариуцах ажил
1	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Аяныг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах, олон нийтэд мэдээлж сурталчилах, оролцогч байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, цэвэрлэгээний дүн мэдээг нэгтгэж, хотын Ерөнхий менежерт танилцуулах.
2	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	Аяны хугацаанд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гаднах орчны цэвэрлэгээ үйлчилгээний байдалд тавих хяналтыг сайжруулах, аянд оролцоогүй болон

		хангалтгүй оролцсон байгууллагуудад мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх, хариуцлага тооцох. Аяны үеэр ажилласан тайлан мэдээг ЗАА-ны ХХУЗХ-т 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн дотор ирүүлэх.
3	Нийслэлийн Хөдөлмөрийн газар	Дүүргүүдийн Хөдөлмөрийн хэлтэс, хороодтой хамтран ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж гэр хорооллын гудамж талбай, далан гуу жалганы цэвэрлэгээний ажилд оролцуулах.
4	Хог тохижилтын газар ОНӨААТҮГ	Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг 24 цагаар тасралтгүй явуулах, хог тээвэрлэгч байгууллагуудын хог тээврийн бүртгэл мэдээллийн үйлчилгээг доголдол, сааталгүй үзүүлэх, төвлөрсөн цэг дээр ирсэн хогны мэдээг 7 хоног тутам гаргаж УБ хотын ЗАА-ны ХХУЗХ-т ирүүлэх.
5	Дүүргүүдийн ЗДТГ	Нутаг дэвсгэртээ аяныг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, ажлын төлөвлөгөө, хуваарь баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, аяны ажлын мэдээллийг олон нийтэд сурталчлах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг идэвхтэй хамруулах, Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудаар төвийн хэсгийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх шөнийн тээвэрлэлтийг орой 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн тээвэрлүүлэх нэмэлт хуваарийг батлан, хяналт тавьж ажиллах, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг аяны хугацаанд 2-с доошгүй удаагийн давтамжтай тээвэрлүүлэх. Аяны ажлын явцын мэдээг 7 хоног бүрийн баасан гаригт ХХУЗХ-т ирүүлж байх, Нэгдсэн тайлан мэдээг УБ хотын Захирагчийн ажлын албаны ХХУЗХ болон Шуурхай удирдлага, зохицуулалтын төвд 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн дотор ирүүлэх.
6	Хороо	Нутаг дэвсгэрийнхээ иргэн, БААН-үүдэд аяны талаар мэдээлэл хүргэх, олон нийтийг цэвэрлэгээнд өргөнөөр хамруулж хяналт тавих, цэвэрлэж бөөгнүүлсэн хогийг түргэн шуурхай ачуулах, хог шатаахгүй байхад онцгой анхаарах. Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын шөнийн тээвэрлэлт, гэр хорооллын айл өрхийн хог тээвэрлэлтийн нэмэлт хуваарийн мөрдөлтөнд хяналт тавьж айл өрхийг хог тээвэрлэлтэнд бүрэн хамруулах.

		<p>Хог тээвэрлэгч байгууллагуудын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг бүрэн, хангалттай тээвэрлэсэн эсэх талаар Хорооны Засаг даргын тодорхойлолт, албан бичгийг дүүргийн ТНААХ-т гаргаж өгнө.</p> <p>Аяны явцын мэдээ, нэгдсэн тайлан мэдээг дүүргийн ТНААХ-т хугацаанд нь гаргаж өгөх.</p> <p>Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллын гудамж талбайд үүсдэг ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлүүлж, тээвэрлүүлэх, дахин үүсгэхгүй байх арга хэмжээ авах, сар шинийн баяраар ил задгай хоггүй байлгахад анхаарч ажиллах.</p>
7	Хог хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд	<p>Хариуцсан бүсийн зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг эрчимжүүлж, машин техникийг бэлэн байдалд байлгах.</p> <p>Төвийн бүсийн байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны хорооллын хог хаягдлыг оройны 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд хийх шөнийн тээвэрлэлтийн нэмэлт хуваарь баталж мөрдүүлэх.</p> <p>Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг аяны хугацаанд 2-с доошгүй давтамжтай тээвэрлэж бүрэн хог хаягдалгүй болгох.</p> <p>Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллын гудамж талбайд үүсдэг ил задгай хог хаягдлыг бүрэн тээвэрлэж дахин үүсгэхгүй байх арга хэмжээ авах, сар шинийн баяраар ил задгай хоггүй байлгах талаар анхаарч ажиллах.</p>
8	Монголын СӨХ-ны дээд зөвлөл	<p>СӨХолбоодын захирлуудад аяны талаар нэгдсэн мэдээлэл, чиглэл өгөх, удирдан зохион байгуулж ажиллах, хариуцсан байрных нь гадна орчин, орцны цэвэрлэгээг хийлгэх, иргэдэд аяны талаар мэдээлэл хүргэх, цэвэрлэгээнд татан оролцуулах, ажлын мэдээг СӨХ-ны дээд зөвлөл болон харьяа хороондоо өгөх, СӨХ-ны дээд зөвлөл нэгдсэн мэдээ гарган УБ хотын ЗАА-ны ХХУЗХ болон Шуурхай удирдлага, зохицуулалтын төвд ирүүлэх.</p>
9	Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ	<p>Аяны явцын мэдээг тогтмол нэгтгэж эцсийн дүн мэдээг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулах.</p>
10	Хөндлөнгийн хяналтын ТББ-ууд	<p>Аян хүрээнд дүүргүүдийн ЗДТГ, хороод, нийслэл, дүүргийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт тавьж ажиллах.</p>

		<p>Хог тээвэрлэлт доголдож байгаа, хог хаягдал их хэмжээгээр үүссэн зайлшгүй цэвэрлэх, тээвэрлэх шаардлагатай байршлуудын судалгааг дүүрэг бүрээр гаргаж цэвэрлүүлэх, тээвэрлүүлэх, арга хэмжээ авах. Төвийн бүсийн байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны хорооллын хог хаягдлыг оройны 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд хийх шөнийн тээвэрлэлтэд хяналт тавьж биелэлтийг хангуулж ажиллах.</p> <p>Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг аяны хугацаанд 2-с доошгүй давтамжтай тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж биелэлтийг хангуулж ажиллах</p>
--	--	---

Тав. Аяны дүнг тайлагнах.

5.1. Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс аяны явцын мэдээг 7 хоногоор гарган нэгтгэж УБ хотын Ерөнхий менежерт мэдээллэж ажиллана.

5.2. Дүүргийн Засаг даргын Тамгын газар дүүргийн хэмжээний эцсийн дүн мэдээг нэгтгэж УБ хотын ЗАА-ны ХХУЗХ болон Шуурхай удирдлага, зохицуулалтын төвд 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн дотор ирүүлнэ.

5.3. Шуурхай удирдлага, зохицуулалтын төв дүүргүүдийн дүн мэдээг нэгтгэж 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны зөвлөлийн хуралд танилцуулна.

Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны
Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс